



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2017 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 18

Номгон

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
шагналын журам шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 62.2 дахь заалт, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4, 20 дугаар зүйлийн 20.1.12 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналын журмыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Шагналын журмын хэрэгжилтийг хангаж, нийтэд сурталчилж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга /С.Үнэнбуян/-д даалгасугай.

3. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 38 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ц. ОТГОНБАЯР

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 01 дүгээр сарын 18-ны
өдрийн 18 дугаар тогтоолын хавсралт



АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ШАГНАЛЫН ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

Эх орныхоо бүтээн байгуулалт, Баянхонгор аймгийг хөгжүүлэх үйлсэд амжилт гарган бүтээлч хөдөлмөрөө зориулсан хүмүүсийг үнэлж, урамшуулж алдаршуулахад энэ журмын зорилго оршино.

Хоёр.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналын төрөл

2.1 Аймгийн “Хүндэт иргэн” цол тэмдэг, мөнгөн шагнал

2.2 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Соёрхол одон”, мөнгөн шагнал

2.3 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэтгэл”, мөнгөн шагнал

Гурав.Шагнал олгох журам

3.1 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналаар шагнуулах иргэний талаар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, аймаг, сумдын Засаг даргын Тамгын газрын болон аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг хэрэгжүүлэгч агентлагын тодорхойлолт, холбогдох материалын хамт аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албанд ирүүлнэ. Шагналд тодорхойлж буй иргэний материал нь дараах бүрдэлтэй байна. Үүнд:

3.1.1 Шагнуулах тухай үндсэн байгууллагын тодорхойлолтыг үндэслэн гаргасан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон аймгийн ЗДТГазар, түүний бодлогын хэлтсээс ирүүлсэн хүсэлтийн аль нэгийг хавсаргасан байна.

3.1.2 Шагнуулах иргэний тодорхойлолт

3.2 Аймгийн шагналаар шагнуулахаар сум, байгууллагаас өргөн мэдүүлэхдээ дараах бичиг баримтыг бүрдүүлсэн байна. Үүнд:

3.2.1 Нэр дэвшигчийн анкет

3.2.2 Ажил байдлын тодорхойлолт

3.2.3 Хамт олны хурлаар хэлэлцсэн тухай албан тэмдэглэл

3.2.4 Холбогдох хэлтэс, агентлагуудын болон Сум, байгууллагын даргын гарын үсэг бүхий өргөн мэдүүлэх албан бичиг зэрэг болно.

3.3 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албаны шагнал хариуцсан ажилтан материалын бүрдлийг нягтлан шалгаж аймгийн

иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны даргаар хянуулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлнэ.

3.4 Шагналыг нэг иргэнд давхардуулж олгохгүй.

3.5 Шагналыг нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдөр, тухайн сум, байгууллагын тэгш ойг тохиолдуулан олгоно.

3.6 Дараах болзлыг хангасан иргэнийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналаар шагнана. Үүнд:

3.6.1 Аймгийн **“Хүндэт иргэн” цол тэмдэг**-ийг аймаг /хот/, сумыг бүтээн байгуулах, хөгжүүлэх, иргэдийн амьдрал ахуйг дээшлүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, шинэ технологи нэвтрүүлэхэд өөрийн тодорхой хувь нэмрийг оруулсан, нутгийн захиргааны байгууллагад хөдөлмөрийн өндөр амжилт үзүүлсэн болон аймаг, орон нутгийн нэрийг тив дэлхийд гаргасан, тэр нь улс орны хэмжээнд үнэлэгдэж, иргэдийн сэтгэл санаанд нийцэж, хоногшсон нэр хүндтэй Монгол Улсын болон гадаадын иргэнд аймгийн **“Хүндэт иргэн”** цол, шагнал олгоно. Аймгийн **“Хүндэт иргэн”** цолоор шагнагдсан хүнийг аймгийн Хүндэт дэвтэрт бичиж алдаршуулна.

3.6.2 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын **“Соёрхол одон”-гоор** бүх хэвшлийн байгууллагуудад 15-аас доошгүй жил ажилласан, үүнээс тухайн ажлын байранд 5-аас доошгүй жил ажиллаж амжилт гаргаж Баянхонгор аймгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан иргэнийг шагнана.

3.6.3 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын **“Хүндэтгэл”** шагналаар бүх хэвшлийн байгууллагад 10-аас доошгүй жил ажиллаж үүнээс тухайн ажлын байранд 3-аас доошгүй жил ажиллаж амжилт гарган Баянхонгор аймгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан иргэнийг шагнана.

3.6.4 Онцгой даалгаварыг амжилттай биелүүлсэн, хөдөлмөрийн гоц амжилт гаргасан, улс, олон улс, дэлхийн түвшинд урлаг, спортын өндөр амжилт гаргасан, шинжлэх ухааны нээлт хийсэн иргэнийг дээрх шалгуурыг харгалзахгүйгээр шагнаж болно.

3.6.5 Аймаг, сумын хөгжилд хувь нэмэр оруулж, нийгмийн хариуцлагаа биелүүлдэг, салбартаа тогтвортой амжилт гаргаж буй байгууллага, хамт олныг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналаар шагнаж болно.

3.6.6 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын **“Хүндэт иргэн”** цол тэмдгийг 300000 төгрөг, **“Соёрхол одон”-г** 25000 төгрөг, **“Хүндэтгэл”-ийг** 10000 төгрөгийн мөнгөн урамшуулал дагалдана.

3.6.8 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Соёрхол одон”, “Хүндэтгэл” шагналуудын дагалдах мөнгөн шагналуудыг тухайн иргэнийг тодорхойлсон албан газар, байгууллага нь хариуцах бөгөөд дээрх зардлыг олгохгүйгээр шагналын нэр хүндийг үнэгүйдүүлсэн, шагнуулсан иргэнийг хүндэтгээгүй тохиолдолд тухайн байгууллагын тодорхойлолтыг үндэслэн дахин шагнал олгохгүй.

3.6.9 Харьяалах албан газар, байгууллагагүй чөлөөт уран бүтээлчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, өндөр настан, малчдад сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тодорхойлолт, хүсэлтийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Соёрхол одон”, “Хүндэтгэл” шагналуудын дагалдах мөнгөн шагналуудыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгох бөгөөд шагналыг хавтгайруулан олгохгүй.

3.6.10 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аль нэг Тэргүүлэгч, Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга гардуулна. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Тэргүүлэгч, төлөөлөгч, Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга очиж гардуулах бололцоогүй нөхцөлд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын зөвшөөрснөөр тухайн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, Засаг дарга, тухайн байгууллагын дарга, эрхлэгч нар гардуулж болно.

Дөрөв. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгох шагналын загвар

4.1 Аймгийн “Хүндэт иргэн” шагналын үнэмлэх, тэмдэг:

4.1.1 Аймгийн “Хүндэт иргэн” үнэмлэх нь /цэнхэр, улаан/ өнгийн хавтастай байх бөгөөд нүүрэн талд нь аймгийн сүлдийг дүрсэлж доод талд нь “Баянхонгор аймгийн Хүндэт иргэн” гэж бичсэн байна.

4.1.2 Доторх хуудас нь түмэн наст хээ бүхий шаргал өнгийн дэвсгэртэй байх бөгөөд Баянхонгор аймгийн хүндэт иргэн, дугаар, шагнагдсан тухай шийдвэрийн товч утгыг бичиж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга гарын үсэг зурахаар нэрийг нь хэвлэсэн байна.

4.1.3 Тэмдэг нь зүүлт бүхий 2,5 см-ийн радиустай дугуй дотор аймгийн сүлдтэй байх бөгөөд алтадмал металь дэвсгэр дээр аймгийн сүлдийг цутгасан, зүүлт хэсэг дээр “Баянхонгор аймгийн Хүндэт иргэн” нэрийг алтадмал өнгөөр товойлгож гаргасан байна.

4.2 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Соёрхол одон” шагналын үнэмлэх, тэмдэг

4.2.1 Аймгийн “Соёрхол одон”-ийн үнэмлэх нь тэмдэгийн хамт хүчинтэй бөгөөд дөрвөн зүг, найман зовхисыг бэлгэдсэн мөнгөлөг дэвсгэр, алтадмал суурь

дээр аймгийн сүлдийг товойлгон дүрсэлж цулгуй шаргал дэвсгэр дээр байршуулсан байна.

4.2.2 Үнэмлэхний хуудас нь түмэн наст хээ бүхий хөх, шаргал өнгийн дэвсгэртэй байх бөгөөд Баянхонгор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Соёрхол одон” тэмдэгээр шагнагдсан тухай дугаар, шагнагдсан тухай шийдвэрийн товч утгыг бичиж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга гарын үсэг зурахаар нэрийг нь хэвлэсэн байна.

4.3 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэтгэл” шагнал

4.3.1 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэтгэл” шагнал нь А-4 хэмжээний түмэн наст хээгээр хүрээлэгдсэн цагаан өнгийн хавтастай байх бөгөөд нүүрэн талд нь аймгийн сүлдийг дүрсэлж доод талд нь “ХҮНДЭТГЭЛ” гэж бичсэн байна.

4.3.2 Доторх хуудас нь түмэн насан хээ бүхий шаргал өнгийн дэвсгэртэй байх бөгөөд Баянхонгор аймгийн хүндэт өргөмжлөл, дугаар, шагнагдсан тухай шийдвэрийн товч утгыг Монгол, крилл бичгээр бичиж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга гарын үсэг зурахаар нэрийг нь хэвлэсэн байна.